



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Төрийн өмчид хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харгуй” ТӨХК-ийн авлагад тооцон авсан нийт 57,236,588.10 (тавин долоон сая хоёр зуун гучин зургаан мянга таван зуун наян найман төгрөг арван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг тус компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Харгуй” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Х.Оргил-Эрдэнэ, гүйцэтгэх захирал Н.Болдбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201108

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 02
дугаар сарын 04-ний өдрийн 37
дугаар тогтоолын хавсралт

"Харгуй" ТӨХК-ийн балансад бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	хэмжих нэгж	талбай	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын 3-р багт байрлах 24 айлын орон сууцны 2 давхарт байрлах 07 тоот 2 өрөө орон сууц	2020	м2	45.05	57,236,588.1
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				57,236,588.10 (тавин долоон сая хоёр зуун гучин зургаан мянга таван зуун наян найман төгрөг арван мөнгө)